

1.ӨРХ, ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

1.1 2014 оны жилийн эцсийн байдлаар манай аймаг 15891 хүн, үүнээс эрэгтэй 7937, эмэгтэй 7954 хүнтэй боллоо. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал хүн ам 1.2 хувиар, үүнээс эрэгтэй 2.1 хувиар, эмэгтэй 0.4 хувиар өссөн үзүүлэлттэй гарлаа. Нийт хүн амын 49.9 хувийг эрэгтэйчүүд, 50.1 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.

Нийт хүн амын 32.5 хувийг 0-15 насны хүүхэд, 62.0 хувийг хөдөлмөрийн насны буюу 16-59 насны хүмүүс, 5.5 хувийг өндөр настнууд буюу 60 ба түүнээс насны хүмүүс эзэлж байна.

Тайлант онд 4749 өрх тоологдсон нь өмнөх оноос 1.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Шилжин ирсэн хүн 748 байгаа нь өмнөх оноос 9.2 хувиар буурч, шилжин явсан хүн 748 болж өмнөх оноос 4,6 хувиар өссөн байна. Шилжин ирэгсдийн 308 буюу 41,2 хувь нь Улаанбаатар хотоос, 134 буюу 17,9 хувь нь Дундговь аймгаас, 113 буюу 15,1 хувь нь Дорноговь аймгаас, бусад аймгаас 25,8 хувь нь ирсэн байна. Шилжин явагчдын 481 буюу 64,3 хувь нь Улаанбаатар хотруу, 82 буюу 10,9 хувь нь Дорноговь аймаг руу, 76 буюу 10,2 хувь Дундговь аймаг руу явсан байна.

Аймгийн хэмжээнд бүтэн өнчин хүүхэд 27, үүнээс эмэгтэй 11, хагас өнчин хүүхэд 177, үүнээс эмэгтэй 75 байгаа нь өмнөх оны мөн үеэс бүтэн өнчин хүүхэд 7,4-12,4 хувийн өсөлттэй гарчээ. Мөн өрх толгойлсон эцэг, эх 792 бүртгэгдсэн нь өмнөх оноос 5,7 хувиар буурсан байна. Ганц бие өндөр настан 197, хөгжлийн бэрхшээлтэй иргэд 557 байгаа нь өмнөх оноос өсөлттэй гарлаа.

2013 оны жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд 503 хүүхэд эхээс мэндэлсний 249 нь хүү, 254 нь охин байлаа. Нийт 85 хүн нас барсан байна. Бүртгүүлсэн гэр бүл 69, цуцалсан гэр бүл 27, үрчлэгдсэн хүүхэд 7 бүртгэгдлээ. Төрөлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12.0 хувиар, өмнөх сараас 10.1 хувиар тус тус өссөн

Нас баралт 85 байгаа нь өмнөх оноос 22,0 хувиар буурсан, өмнөх сараас 9.4 хувиар өссөн байна.

Бүртгүүлсэн гэр бүл өмнөх оноос 11.3 хувиар, өмнөх сараас 13.04 хувиар өссөн байна.

Цуцалсан гэр бүл өмнөх оны мөн үеэс 22.7 хувиар өссөн үзүүлэлт гарлаа. Харин үрчлэгдсэн хүүхдийн тоо 7 байгаа нь өмнөх оны мөн үеийн үзүүлэлттээс 12.35 хувиар буурсан байна.

2013 онд цэргийн насны 4931 хүн бүртгэгдсэн бөгөөд тэдний 3265 нь буюу 66,2 хувь нь цэргийн алба хаасан, 1663 нь буюу 33,8 хувь нь цэргийн алба хаагаагүй байна.

2013 оны жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд 928 оюутан суралцаж байгаагийн 452 буюу 47,7 хувь нь эмэгтэй оюутнууд эзэлж байна.

2013 онд хөдөлмөрийн насны хүн ам 9870, үүнээс 4990 нь ажиллагчид байгаагийн 2375 буюу 74,1 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Тэтгэврийн насны ажиллагчид 57 байгаа нь нийт ажиллагчдын 1,2 хувийг эзэлж байна. Хөдөлмөрийн хэлтэст 405 бүртгэлтэй ажилгүйчүүд байгаагийн 252 буюу 62,2 хувь нь эмэгтэйчүүд, хөдөлмөрийн насны ажил эрхлээгүй 2626 байгаагийн 1417 буюу 54,0 хувь нь эмэгтэйчүүд, хөдөлмөрийн насны өдрийн ангид суралцагсад 1412 байгаагийн 764 буюу 54,1 хувь нь эмэгтэй, хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадваргүй 437 иргэн бүртгэгдсэний 206 буюу 47,1 хувь нь эмэгтэйчүүд байна.

Хүн амын тоог сумдаар мэдээлбэл:

Сумд		2012 он	2013 он	Өсөлт Бууралт	Хувь
Баянтал	Нийт хүн ам	961	1048	87	108.3
	Эрэгтэй	489	534	45	108.4
	Эмэгтэй	472	514	42	108.2
Сүмбэр	Нийт хүн ам	11279	11570	291	102.5
	Эрэгтэй	5557	5667	110	101.9
	Эмэгтэй	5722	5903	181	103.1
Шивээговь	Нийт хүн ам	3000	3076	76	102.5
	Эрэгтэй	1530	1571	41	102.6
	Эмэгтэй	1470	1505	35	102.4
Дүн	Нийт хүн ам	15240	15694	454	102.9
	Эрэгтэй	7576	7772	196	102.5
	Эмэгтэй	7664	7922	258	103.3



2013 оны жилийн эцсийн суурин хүн амын тоог
насны бүлэглэлээр үзүүлбэл:

Насны бүтэц	Аймгийн дүн	Баянтал сум	Сүмбэр сум	Шивээговь сум
0-4.	1971	136	1421	414
5-9.	1483	97	1107	279
10-14.	1254	79	931	244
15-19	1443	98	1079	266
20-24	1563	102	1162	299
25-29	1579	98	1132	349
30-34	1303	91	940	272
35-39	1126	91	820	215
40-44	1076	54	811	211
45-49	895	62	665	168
50-54	691	50	510	131
55-59	471	46	340	85
60-64	261	12	194	55
65-69	200	10	150	40
70-74	165	12	127	26
75-79	118	5	100	13
80-84	55	3	46	6
85-89	28	1	25	2
90-94	12	1	10	1
95-99	-	-	-	-
100+	-	-	-	-
Нийт	15694	1048	11570	3076

Насны бүлэглэлээс харахад 70 ба түүнээс дээш настан 378, 80 ба түүнээс дээш настан 95, 90 ба түүнээс дээш настан 12, Аймгийн хамгийн өндөр настан нь Баянтал сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт амьдарч байна.

2012 оны нас хүйсийн суварга

2013 оны нас хүйсийн суварга



Өрхийн тоог сумдаар үзүүлбэл:

Сумд	Он		Өсөлт бууралт	Хувь
	2012	2013		
Баянтал	335	318	-17	94.3
Сүмбэр	3271	3390	119	103.5
Шивээговь	967	972	5	100.5
Дүн	4573	4680	107	102.3

Нийт өрхийг байршлаар нь авч үзвэл:

- Аймгийн төвд 2815 өрх буюу нийт өрхийн 60.1 хувь
- Сумын төвд 817 өрх буюу нийт өрхийн 17.5 хувь
- Хөдөө багт 1048 өрх буюу нийт өрхийн 22.4 хувь нь тус тус амьдарч байна.

2013 онд тоологдсон 4680 өрхийг сууцны төрлөөр нь авч үзвэл:

- Гэрт амьдардаг өрх 1861
- Байшинд амьдардаг өрх 2812
 - Орон сууцанд амьдардаг өрх 1486
 - Бие даасан тохилог сууцанд амьдардаг өрх 5
 - Сууцны тусдаа байшинд амьдардаг өрх 849
 - Нийтийн байранд амьдардаг өрх 472
- Бусад сууцанд амьдардаг өрх 7 байна.

1.2. Жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээгээр бүтэн өнчин хүүхэд 25 байгаагийн 12 нь эмэгтэй. Хагас өнчин 191 хүүхэд байдгаас 0-4 настай 14, 5-9 настай 34, 10-14 настай 67, 15-18 настай хүүхэд 76 байна. Хагас өнчин хүүхдийн 80 нь буюу 41.9 хувь нь эмэгтэй хүүхэд байна.

Өмнөх оны мөн үеэс бүтэн өнчин хүүхэд 4 хувиар, хагас өнчин хүүхэд 11.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд 557 бүртгэгдсэнээс эмэгтэй 236 , төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй 217 бүртгэгдсэн нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд өмнөх оноос 8,1 хувиар өссөн мэдээтэй байна. Нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс 0-14 насны хүүхэд 27.

2013 онд тэтгэвэр тэтгэмж тогтоогдоогүй 3 өндөр настан байна. Үүнээс 60 – аас дээш настай 1, 55 ба түүнээс дээш настай /эмэгтэй/ 2. Эдгээр өндөр настанууд нь Сүмбэр суманд амьдарч байна.

18 хүртэлх насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй өрх 107, 7 ба түүнээс дээш хүүхэдтэй өрх 3 , ганц биеэрээ амьдарч байгаа өндөр настан өрхийн тоо 197 бүртгэгдсэн ба үүнээс 60 ба түүнээс дээш настай 52 , 55 түүнээс дээш настай / эмэгтэй / 145 өндөр настан амьдарч байна.

Аймгийн хэмжээнд өрх толгойлсон эмэгтэй 643 амьдарч байгаа нь өмнөх оноос 8.9 хувиар өссөн байна.

Үүний: 368 нь буюу 57,2 хувь нь 3 хүртэл хүүхэдтэй

245 нь буюу 38,1 хувь нь 3-5 хүүхэдтэй

30 нь буюу 4,7 хувь нь 6-аас дээш хүүхэдтэй хүмүүс байлаа.

1.3. Хүн амын амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой өрхийн зарим үзүүлэлтүүдийг тайлант оны байдлаар авч үзвэл (Тайлант онд АДТүвшин Төвийн бүсэд 132400 төгрөг байлаа.)

Ядуу өрх 413 , өрхийн гишүүд 1727 байгаа нь нийт өрхийн 8.8 хувийг, нийт хүн амын 11.0 хувийг эзэлж байгаа бөгөөд энэ нь өмнөх оны мөн үеэс ядуу өрхийн тоо 11,9 хувиар иргэд 10,9 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Нийт ядуу өрхөөс нэн ядуу өрх 172, өрхийн гишүүд нь 765 байгаа нь нийт ядуу өрхийн 41,6 хувийг, ядуу өрхийн гишүүдийн 44.2 хувийг эзэлж байгааг өмнөх оны мөн үетэй харьцуулбал ядуу өрх 16,5 хувиар, өрхийн гишүүд 11,6 хувиар буурсан байна.

Ядуу иргэдийн 22,4 хувь нь боловсролгүй, 21,7 хувь нь ЕБС-д суралцагсад байна. Энэ онд орон гэргүй ядуу өрх 14 бүртгэгдсэний 92,8 хувь нь нэн ядуу өрх байлаа. Аймгийн хэмжээгээр ядуу өрхүүдэд 4,1 сая.төгрөгийн мөнгөн тусламж , 7,5 сая төгрөгийн бусад тусламжийг олгосон байна.

1.4. Жилийн эцсийн байдлаар бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 405 байгаагаас 252 эмэгтэй байгаа нь нийт ажилгүй иргэдийн 62,2 хувийг эзэлж байна.

Мөн хугацаанд нийт 363 хүн байнгын шинэ ажлын байраар хангагдсан байна. Үүний 229 нь буюу 63,08 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Шинэ ажлын байранд орсон иргэдийг насны бүлгээр нь ангилбал 15-24 настай 67, 25-34 настай 112, 35-44 настай 86, 45-59 настай 98 иргэн байна.

Шинээр бий болсон ажлын байрыг эдийн засгийн үйл ажиллагааны чиглэлээр авч үзвэл 25,1 хувь нь үйлчилгээний салбарт , 10,4 хувь нь худалдааны салбарт , 10,4 хувь нь уул уурхайн салбарт, 12,4 хувь нь боловсруулах үйлдвэрт, 17,6 хувь нь ХАА-н салбарт , 12,1 хувь нь зочид буудал нийтийн хоолны салбарт , 12 хувь нь бусад салбарт бий болсон байна.

1.5. Тайлант онд халамжийн хэлтсээс 5776 хүнд 2015,6 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт халамж үйлчилгээ үзүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 25,2 хувиар буурсан байна.

Үзүүлэлт	Хамрагдсан иргэдийн тоо		Олгосон мөнгөн дүн /сая.төг/	
	2012 он	2013 он	2012 он	2013 он
Халамжийн тэтгэвэр	311	899	306,0	959,9
Нөхцөлд мөнгөн тэтгэмж	161	910	75,2	138,5
Нөхцөлт мөнгөн тусламж	126	156	14,2	15,1
Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамж үйлчилгээ	40	51	5,2	26,2
Хүний хөгжил сангийн хишиг хувь олголт	14181	-	1884,5	-
Алдарт эхийн одонтой эхчүүдийн тусламж	1093	1097	157,7	151,8
Ахмад настны хөнгөлөлт	829	796	35,2	247,9
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөнгөлөлт	68	491	27,0	51,2
Жирэмсэн амаржсаны тэтгэмж	593	1253	169,0	379,6
Алдар цолтой ахмад настны тэтгэмж	11	123	19,1	45,4
Бусад сангаас	21	-	1,0	-
Бүгд	17434	5776	2694,1	2015,6

2. ХӨДӨӨ АЖ АХУЙ

2.1. 2013 оны жилийн эцсээр манай аймаг 272,8 мянган толгой малтай болсон нь өмнөх оноос 20,6 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Үүнээс: Тэмээ 821 толгой, адуу 12122 толгой, үхэр 7697 толгой, хонь 120953 толгой, ямаа 131171 толгой тус тус тоологджээ.

Аймгийн хэмжээнд 872 малтай өрх тбайгаагаас 563 малчин өрхийн 1975 ам бүлийн гишүүд тоологдсон ба нийт малчид 983, үүнээс эмэгтэй малчид 451 буюу нийт малчдын 45.9 хувийг эзэлж байна

Нийт малчдыг насны бүлгээр нь авч үзвэл :

15-34 нас - 326 малчин буюу 33,2 хувь

35-59 нас - 523 малчин буюу 53.2 хувь

60 аас дээш насны - 134 малчин буюу 13.6 хувийг тус тус эзэлж байна.

Эрлийз, цэвэр үүлдрийн мал 2713, үүнээс “Сүмбэр” хонь 767 толгой Сүмбэр - Монгол эрлийз хонь 988 толгой тоологдлоо .

Нийт малын дүнд тэмээ 0.3 хувь, адуу 4,4 хувь, үхэр 2,8 хувь, хонь 44,3 хувь, ямаа 48,1 хувийг эзэлж байна.

Малын төрөл	Сумд			ДҮН
	Баянтал	Сүмбэр	Шивээговь	
Тэмээ	160	582	79	821
Адуу	2678	8334	1110	12122
Үхэр	1030	5595	1072	7697
Хонь	19879	86607	14467	120953
Ямаа	18419	97612	15140	131171
Бүгд	42166	198730	31868	272764

Малын тоо (толгойгоор)

Малын төрөл	2012 он	2013 он	Хувь	Зөрүү
Толгойн тоогоор	226102	272764	20,6	46662
Тэмээ	628	821	30,7	193
Адуу	9586	12122	26,5	2536
Үхэр	5606	7697	37,3	2091
Хонь	99406	120953	21,7	21547
Ямаа	110876	131171	18,3	20295

2.2 2013 онд малтай өрх 872 бүртгэгдсэн бөгөөд энэ онд манай аймгаас 55 мянгат малчин төрлөө. Өмнөх онтой харьцуулбал 35,7 хувиар нэмэгдсэн байна. Үүнд:

Сүмбэр сумын мянгат малчин	37
Баянтал сумын мянгат малчин	13
Шивээговь сумын мянгат малчин	5

Мянгат малчдаас хамгийн их малтай нь Сүмбэр сумын 4 дүгээр багийн иргэн Д.Эрдэнэ-Очир /2460 толгой мал/, хамгийн их тэмээтэй сүмбэр сумын 4 дүгээр багийн иргэн З.Бадарч /130 толгой /, хамгийн их адуутай нь Баянтал сумын 2 дугаар багийн иргэн Л.Батнасан /355 толгой /, хамгийн их үхэртэй нь Сүмбэр сумын 4 дугаар багийн иргэн М.Батсайхан /156 толгой /, хамгийн их хоньтой нь Сүмбэр сумын 4 дугаар багийн иргэн Ц.Гурвантамир /2020 толгой /, хамгийн их ямаатай нь Сүмбэр сумын 4 дүгээр багийн иргэн Д.Эрдэнэ-Очир /1400 толгой / нар байлаа.

Малтай өрхийн малын тоог бүлэглэлтээр авч үзвэл:

10 хүртэл толгой малтай	28
11-30 толгой малтай	93
31-50 толгой малтай	79
51-100 толгой малтай	120
101-200 толгой малтай	144
201-500 толгой малтай	227
501-999 толгой малтай	126
1000-1499 толгой малтай	39
1500-2000 толгой малтай	10
2001 түүнээс дээш толгой малтай	6 өрх байна.

2.3 2013 онд аймгийн хэмжээнд төллөвөл зохих эх малын 92,8 хувь буюу 95581 мал төллөж, гарсан төл 96965 толгой, үүнээс: 93830 толгой төл бойжсон бөгөөд төл бойжилт 96,8 хувьтай байна.

Бойжсон төлийг төрлөөр нь авч үзвэл:

Сумд	Төллөвөл зохих хээлтэгч	Төллөсөн хээлтэгч	Төллөлтийн хувь	Хорогдсон төл	Бойжсон төл
Баянтал	14727	15192	103,2	389	15275
Сүмбэр	76738	69074	90,0	2723	67178
Шивээговь	11479	11315	98,6	23	11377
ДҮН	102944	95581	92,8	3135	93830

2012 онд 1442 төл хорогдсон бол 2013 онд 3135 төл хорогдож өнгөрсөн оны мөн үеэс 2,2 дахин өссөн ба нийт хорогдсон төлийн 69,2 хувийг ишиг, 27,7 хувийг хурга эзэлж байна.

2.4. 2013 оны жилийн эцсийн байдлаар 1828 том мал зүй бусаар хорогдсон нь өмнөх оны том малын хорогдлоос 2,1 дахин өссөн байна.

Малын зүй бус хорогдол /толгой/

Он	Бүгд	Үүнээс:				
		Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
2005	311	-	7	8	137	159
2006	1020	3	61	66	471	419
2007	79	2	16	12	34	15
2008	6824	23	715	219	2389	3478
2009	7367	1	376	238	2730	4022
2010	15316	6	265	171	5993	8881
2011	314	8	15	8	171	112
2012	853	5	21	19	335	473
2013	1826	3	23	21	675	1104

Малын зүй бус хорогдлыг сумдаар үзүүлбэл:

Сумд	Хорогдсон том мал		Оны эхний малд эзлэх хувь	
	2012 он	2013 он	2012 он	2013 он
Баянтал	69	515	0.3	1,5
Сүмбэр	753	1184	0.5	0,7
Шивээговь	31	127	0.1	0,5
Дүн	853	1826	0.4	0,8

2.5. Оны эцэст 124,9 мянган хээлтэгч мал байгаа нь өнгөрсөн оны хээлтэгч малаас 21,3 хувиар буюу 21,9 мянган толгойгоор өсчээ.

Хээлтэгч малыг өмнөх онтой харьцуулбал: /толгой/

Сумд	Он		Зөрүү	Хувь
	2012	2013		
Баянтал	14727	18701	3974	21,2
Сүмбэр	76898	92443	15545	16,8
Шивээговь	11319	13758	2439	17,7
Дүн	102944	124902	21958	21,3

2.6. Аймгийн дүнгээр цэвэр үүлдэр, эрлийз, нутгийн шилмэл омгийн 2713 толгой мал тоологдсон бөгөөд цэвэр үүлдэр, эрлийз, нутгийн шилмэл омгийн малыг төрлөөр нь ангилбал:

- Цэвэр үүлдрийн “ Сүмбэр “ 767 толгой
- Сүмбэр Монгол эрлийз 988 толгой
- Бусад үүлдэр 958 толгой тус тус тоологдсон байна .

2.7. 2013 онд аймгийн хэмжээнд нийт 7,71 га талбайгаас 38,6 тн төмс, 6,89 га талбайгаас 34,8 тн хүнсний ногоо, 7,1 га талбагаас 24,6 тн тэжээлийн ургамал хурааж авсан нь өмнөх оны мөн үеэс нийт хураасан талбай 39,6 хувиар буюу 1,6 дахин , хураасан ургац 21,4 хувиар буюу 1,3 дахин өссөн үзүүлэлттэй байна.

2.8. Хүн ам , мал , хөдөө аж ахуйн тэжээвэр амьтдын 2013 оны тооллогын дүнгээс үзэхэд аймгийн дүнгээр гахай, шувуу 1034 тоологдлоо.

Нийт 238 гахай үүнээс:

хээлтэгч 86
хээлтүүлэгч 20
бусад 132

Нийт 796 шувуу үүнээс:

үндсэн эх 764
хээлтүүлэгч 32

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад гахайны тоо 41,7 хувиар өсч, шувууны тоо 34,3 хувиар буурсан байна .

3. АЖ ҮЙЛДВЭР, БАРИЛГА

3.1 Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн мэдээг ШОНУ, Ус-Ду, Тохижилт-Сүмбэр, Талын илч, Илчлэг-шивээ, Илчит сансар, Чойр хайрхан зэрэг томоохон аж ахуйн нэгж байгууллагуудаас авдаг. Эдгээр аж ахуйн нэгж байгууллага нь 2013 оны жилийн эцсийн байдлаар 33616,6 сая.төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 33248,7 сая төгрөгийн бүтээгдэхүүн борлуулсан байна.

Шивээ-Овоо хувьцаат компани нь нийт бүтээгдэхүүний 94,8 хувийг, нийт борлуулалтын 93,9 хувийг хийж байна.

Шивээ-Овоо хувьцаат компани нь зах зээл дээр 1 тонн нүүрсийг 19866 төгрөгөөр худалдаалж байна.

Шивээ-Овоо хувьцаат компаний борлуулалтын үзүүлэлтийг танилцуулбал:

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Жилийн эхнээс гүйцэтгэл	
		2012 он	2013 он
Бүтээгдэхүүн борлуулалт /үнийн дүнгээр/	Сая.төг	25879,2	31242,6
Нүүрс борлуулалт /биет хэмжээ/	Мян.тн	1723,4	1925,7
Нүүрс гаргалт /биет хэмжээ/	Мян.тн	1751,8	1964,4
Нийт бүтээгдэхүүн /үнийн дүнгээр/	Сая.төг	26581,3	31870,4
Ажиллагсдын тоо	Хүн	468	495

ШОНУурхайн үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал:

- Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт мөнгөн дүнгээр 19,9 хувиар,
- Бүтээгдэхүүн борлуулалт мөнгөн дүнгээр 20,7 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна

3.2 Аймгийн хэмжээний төв суурин газруудад халаалт, халуун хүйтэн ус үйлдвэрлэх, бохир татан зайлуулах чиглэлээр Ус Ду, Талын Илч, Илчлэг Шивээ, Илчит сансар зэрэг ОНӨҮГ-ууд үйл ажиллагаа явуулж байна. 2013 онд ус дулааны эдгээр байгууллагууд нь нийт 967379,7 мян.төг хэрэглээний халуун ус үйлдвэрлэн, 149370,9 мян.төг цэвэр ус түгээж, 77028,1 мян.төг бохирыг татан зайлуулсан байна.

3.3 2013 онд барилгын салбараас 6 аж ахуйн нэгж байгууллага сонгогдон мэдээнд хамрагдсан байна. Баянтал, Сүмбэр суманд 945,6 сая төгрөгийн гүйцэтгэлтэй эмнэлэгийн барилгууд, аймгийн шүүхийн барилгын өргөтгөл 383,0 сая төгрөгөөр хийгдэж тус тус ашиглалтанд орсон байна. Сүмбэр суманд 100 хүүхдийн хүчин чадалтай 2 цэцэрлэгийн барилга 391,0 сая төгрөгийн гүйцэтгэлтэй, Онцгой байдлын хэлтсийн барилга 500,1 сая төгрөгийн гүйцэтгэлтэй баригдаж байна.

Сүмбэр сумын нутаг дэвсгэр дээр 2,6 км авто замын ажил 1559,0 сая төгрөгийн гүйцэтгэлтэй хийгдэж байна.

4. ТӨСӨВ САНХҮҮ, БАНК

4.1. 2013 оны жилийн эцсийн байдлаар орон нутгийн төсвийн орлого 4532,1 сая төгрөг буюу 105,9 хувийн гүйцэтгэлтэй байна.

Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэлийг танилцуулбал:

	/өссөн дүнгээр сая.төг/	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Нийт орлого ба тусламжийн орлого	4278,0	4532,1
1.Урсгал орлого	3760,7	4014,8
Татварын орлого	3489,6	3689,9
Татварын бус орлого	271,1	324,9
2.Тусламжийн орлого	517,3	517,3

Дээрх үзүүлэлтээс дүгнэхэд орлогын биелэлт 105,9 хувь, үүнээс урсгал орлогын биелэлт 106,7 хувь, тусламжийн орлогын биелэлт 100,0 хувьтай байна.

Оны эцсийн байдлаар аймгийн хэмжээгээр 15628,6 сая төгрөгийн зарлага санхүүжилт хийгдсэн нь өмнөх оны мөн үеэс 0,1 хувиар буурсан байна.

Төсвийн зарлагын 2013 оны гүйцэтгэлийг танилцуулбал:

	/өссөн дүнгээр сая.төг/	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Бүх зардал	19849,3	15628,6
Урсгал зардал	13536,6	10328,3
Хөрөнгийн зардал	6312,7	5300,3
Байгууллагын тоо	40	40
Ажиллагсадын тоо	749	768

Дээрх үзүүлэлтээс дүгнэхэд төсвийн зардал 21,3 хувийн хэмнэлттэй байна.

Төсөвт байгууллагын өглөг, авлагын мэдээгээр:

Авлагын үлдэгдэл 20,4 сая төгрөг

Өглөгийн үлдэгдэл 57,5 сая төгрөг болоод байна.

Өглөг авлагын мэдээнээс үзэхэд өглөг нь авлагаасаа 2,8 дахин их, өмнөх оны мөн үетэй харьцуулбал авлага 2,9 дахин, өглөг 6,6 дахин өссөн үзүүлэлттэй байна.

4.2. Говьсүмбэр аймагт үйл ажиллагаа явуулж буй банкуудын салбарын эдийн засгийн үйл ажиллагааг 2013 оны эцсийн байдлаар танилцуулъя.

Банкуудын эдийн засгийн үзүүлэлт:

/өссөн дүнгээр/

дд	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Банкууд			Дүн
			Төрийн банк	ХААН банк	Хас банк	
1	Салбар үйлчилгээний цэг	тоо	5	6	2	13
2	Цахим банкны үйлчилгээний хэрэглэгчид	хүн	4153	7151	2375	13679
3	Нийт ажиллагсад	хүн	32	30	14	76
4	Үүнээс : зээлийн эдийн засагч	хүн	6	7	4	17
5	Хадгаламж эзэмшигчид	хүн	2687	2884	5270	10841
6	Хадгаламжийн хэмжээ	сая.төг	3022.3	3172.8	2675	8870.1
7	Хадгаламжийн бүтээгдэхүүн	тоо	10	41	8	59
8	Хадгаламжийн дундаж хүү	хувь	0.9	0.97	1.05	0.97
9	Зээлийн бүтээгдэхүүн	тоо	14	12	14	40
10	Зээлийн дундаж хүү	хувь	1.52	1.7	1.51	1.57
11	Зээл авсан : ААНБ	тоо	2	4	13	19
12	Иргэд	хүн	2009	2704	1466	6179
13	Малчид	хүн	57	195	0	252
14	Зээл олгосон : ААНБ	сая.төг	28.4	5972.9	1181	7182.3
15	Иргэд	сая.төг	7434.04	18182.3	6233.5	31849.8
16	Малчид	сая.төг	197.1	604.0	0	801.1
17	Зээлийн эргэн төлөлт	хувь	96.0	99.9	99.7	98.5
18	Харилцахын тоо	тоо	6885	22208	1961	31054
19	Харилцахын дүн	сая.төг	1619.6	1758.5	497.0	3875.1
20	Карт эзэмшигчдийн тоо	хүн	6273	12129	3056	21458
21	Карт эзэмшигчдэд олгох хүүгийн хэлбэр		3.6	3.6	3	3.4
22	АТМ-н тоо	тоо	1	3	1	5

Банкны эдийн засгийн үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал хадгаламж эзэмшигчдийн тоо 907-өөр буюу 9,1 хувиар, хадагламжийн хэмжээ 3438,5 сая төгрөгөөр буюу 63,3 хувиар, зээл авсан аж ахуйн нэгжийн тоо 6-аар буюу 46,1 хувиар, аж ахуй нэгж байгууллагад олгосон зээлийн хэмжээ 6810,5 сая төгрөгөөр буюу 19,3 дахин, зээл авсан иргэдийн тоо 456-аар буюу 7,9 хувиар, иргэдэд олгосон зээлийн хэмжээ 11005,0 сая төгрөгөөр буюу 52,8 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байлаа.

5. НИЙГМИЙН ДААТГАЛ, БУСАД ДААТГАЛУУД

5.1 Нийгмийн даатгалын сангуудын орлогын төлөвлөгөө 5982,2 сая төгрөгөөр, зарлага 7011,9 сая төгрөгөөр батлагдаж, орлогын төлөвлөгөө 6152,9 сая төгрөг буюу 102,8 хувиар биелэж, зарлагын төлөвлөгөө 6785,2 сая төгрөгийн гүйцэтгэлтэй буюу 96,8 хувийн биелэлттэй гарлаа.

2013 онд нийт давхардсан тоогоор 1639 хүнд 4602,3 сая төгрөгийн тэтгэвэр, 1909 хүнд 699,2 сая төгрөгийн тэтгэмж, 11244 хүнд 788,4 сая төгрөгийн хөнгөлөлттэй эмнэлэг, эмийн сангийн санхүүжилтийг цаг хугацаанд нь бүрэн олгожээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад тэтгэврийн санхүүжилт 13,9 хувиар, тэтгэмжийн санхүүжилт 32,4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

5.2 Говьсүмбэр аймагт Монгол даатгал ХХК, Ард даатгал ХХК, Практикал даатгал ХХК, Мөнх даатгал ХХК-ны Говьсүмбэр аймаг дахь салбарууд даатгалын төрлийн бүтээгдэхүүнээр үйлчилгээ үзүүлж байна.

Даатгалын бүтээгдэхүүний үзүүлэлтийг нэгтгэлээр харуулбал:

дд	Даатгалын бүтээгдэхүүний төрөл	/ өссөн дүнгээр, сая.төг /	
		Орлого	Олгосон нөхөн төлбөр
		2013 он	
1	Тээврийн хэрэгслийн даатгал	62,5	25,4
2	Жолоочийн харицлагын даатгал	94,9	37,2
3	Эд хөрөнгийн даатгал	4,6	33,0
4	Хөдөлмөрийн чадвар түр алдалтын даатгал	23,2	13,4
5	Гэнэтийн ослын даатгал	26,0	4,8
6	Хүүхдийн гэнэтийн ослын даатгал	4,4	0,7
7	Хүнд болон тусгай зориулалтын машин механизмын даатгал	2,0	-
8	Мэргэжлийн хариуцлагын даатгал	1,3	-
9	Ачаа тээвэрлэлтийн даатгал	6,3	-
10	Гэр хашаа байшингийн даатгал	2,1	2,5
11	Нийтийн ба хувийн сууцны даатгал	5,1	0,4
12	Лангуу түрээслэгч жижиглэн худалдаа эрхлэгчдийн даатгал	0,3	-
13	Электорон төнөг төхөөрөмжийн даатгал	0,3	-
14	Бараа материалын үлдэгдлийн даатгал	7,7	-
	Дүн	240,7	117,4

2012 оны байдлаар аймгийн хэмжээнд “ Монгол даатгал “ ХХК-с даатгалын салбарын мэдээг авч байсан бол тайлант оноос 4-н даатгалын байгууллагаас мэдээг авч нэгтгэсэн.

Даатгалын орлогын нийт хэмжээ 240,7 сая төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 37,3 хувиар өссөн байна .

Олгосон нөхөн төлбөрийн хэмжээ 117,4 байгаа нь өмнөх оноос 71,3 хувиар өссөн байна

6. ТЭЭВЭР, ХОЛБОО, ГАЗАР

6.1 Аймгийн хэмжээнд хот доторхи такси үйлчилгээнд “Чойр такси ХХК”, хот хоорондын такси үйлчилгээнд “Их боржигон зам” хоршоо тээврийн үйлчилгээгээ үзүүлж хэвшлээ.

Тээвэр, авто замын газрын мэдээг харуулбал:

	Хэмжих нэгж	2012 он	2013 он
Зорчигч эргэлт	мян.хүн.км	2332,6	2930,6
Тээсэн зорчигч	мян.хүн	10,6	12,2
Тээврийн орлого	мян.төг	8624,9	7058,7
Ажиллагчдын тоо	хүн	7	9

/өссөн дүнгээр/

Тээвэр, авто замын газрын мэдээг өмнөх оны мөн үетэй харьцуулбал зорчигч эргэлт 25,6 хувиар, тээсэн зорчигч 15,1 хувиар тус тус өсч, тээврийн орлого 18,1 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Авто тээврийн үндэсний төвийн Говьсүмбэр аймаг дахь салбарын мэдээгээр 2013 оны байдлаар 3188 тээврийн хэрэгсэл бүртгэгдсэний 2626 нь хувийнх, 562 нь албан байгууллагын тээврийн хэрэгсэл байна.

дд	Тээврийн хэрэгсэлийн төрөл	Бүгд	Үүнээс:	
			Хувийн	Албаны
1	Бүгд	3188	2626	562
2	Суудлын	1481	1271	210
3	Автобус	29	3	26
4	Тусгай зориулалтын	69	43	26
5	Хоёр дугуйт	800	762	38
6	Механизм	19	8	11
7	Чиргүүл	45	16	29
8	Цистерн	61	12	49
9	Зүтгүүр	9	5	4

6.2 2013 оны жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд 405 өрх суурин болон модем хэлбэрээр интернет хэрэглэж байгаа нь аймгийн нийт өрхийн 8,6 хувийг эзэлж байна. Интернеттэй өрхийн нийт гишүүд 1688 байгаа нь хүн амын 10,8 хувийг эзэлж байна.

Аймгийн холбооны газрын 2013 оны мэдээгээр :

Үйлчилгээний нийт орлого 179,3 сая төгрөг, үүнээс хүн амаас орсон орлого 107,6 сая төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс нийт орлого 5,8 хувиар, хүн амаас орсон орлого 74,9 хувиар тус тус өссөн байна. 2013 онд 619 цахилгаан мэдээ дамжуулсан нь өмнөх оны мөн үеэс буурсан байна. Аймгийн хэмжээгээр КТВ суваг 1307 байна. Телефон цэгийн тоо 403 байгаа нь өмнөх оны мөн үеэс 2,0 хувиар өсч, харин айл өрхөд 220 цэг ашиглагдаж байгаа нь өмнөх оны мөн үеэс 4,3 хувиар буурсан байна.

6.3 Газрын харилцаа, Барилга хот байгуулалтын газрын мэдээгээр манай аймгийн нийт газар нутгийн хэмжээ 554.2 мян.га байдаг бөгөөд нийт талбайн:
 68.0 хувийг Сүмбэр сум
 16.5 хувийг Баянтал сум
 15.5 хувийг Шивээговь сум эзэлж байна.

Нийт газрын :

87.0 хувийг- Хөдөө аж ахуйн газар
 1,0 хувийг -Хот, тосгон, суурин газар
 0.9 хувийг -Зам шугам сүлжээний газар
 0.3 хувийг -Усан сангийн газар
 10.8 хувийг- Улсын тусгай хэрэгцээний газар тус тус эзэлдэг

Газрын ангилал	Хэмжих нэгж	Он	
		2012	2013
НИЙТ ГАЗАР	га	554180	554180
Үүнээс: ХАА-н газар	га	527473,9	482241,0
Хот тосгон, суурин газар	га	19845,1	5955,1
Зам шугам сүлжээний газар	га	4480,2	4784,1
Ойн сан бүхий газар	га	-	-
Усны сан бүхий газар	га	1538,0	1538,0
Улсын тусгай хэрэгцээний газар	га	842,8	59661,8

Тайлант жилд нийт газрын 3,9 хувьд хохирол учирсан ба хохирол учирсан газрын 93,5 хувьд хамгаалах арга хэмжээ авчээ.

Газрын төлбөр төлөлт, ноогдуулалтанд 102,9 сая төгрөгийн төлбөр төлөгдсөн нь өмнөх оны мөн үеэс 29,1 хувиар өссөн үзүүлэлт гарлаа.

2013 оны жилийн эцсийн байдлаар 5474 иргэнд 716,8 га газрыг гэр бүлийн хэрэгцээнд нэг удаа үнэгүй өмчлүүлсэн байна.

7. АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГА

Аймгийн татварын хэлтсийн бүртгэлээр 2013 онд 353 байгууллага үйл ажиллагаа явуулсан байна.

Дээрх аж ахуйн нэгж байгууллагыг хариуцлагын хэлбэрээр нь авч үзвэл:

▪ ХК	2
▪ ХХК	156
▪ ББН	4
▪ ЗБН	8
▪ Хоршоо	12
▪ Хадгаламж зээлийн хоршоо	1
▪ ОНӨҮГ	5
▪ Салбар байгууллага	55
▪ Төсөвт байгууллага	54
▪ ТББ	33
▪ Сан	6
▪ Бусад /Шашин-4, ОНБ 13/	17

Өмнөх оны мөн үетэй харьцуулбал аж ахуй нэгж байгууллага 19,3 хувиар нэмэгдсэн байна.

Тайлант онд татан буугдсан буугдсан 2, үйл ажиллагаагаа зогссон 15, түр зогссон 8 аж ахуйн нэгж байгууллага байна.

8. БОЛОВСРОЛ

8.1 2013 оны жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд 928 оюутан байгаагийн 452 буюу 47,7 хувь нь эмэгтэй оюутнууд эзэлж байна. Их дээд сургуульд 765 оюутан суралцаж байгаагаас эмэгтэй 398 буюу 52,03 хувийг, Коллежид нийт 146 байгаагаас эмэгтэй 49 буюу 33,6 хувийг, МСҮТ-д нийт 17 оюутан суралцаж буйгаас эмэгтэй 5 буюу 29,4 хувийг эзэлж байна.

8.2 2013-2014 оны хичээлийн жилийн байдлаар аймгийн хэмжээнд төрийн өмчийн 5 цэцэрлэг, хувийн өмчийн 4 цэцэрлэг нийт 9 цэцэрлэгийн 43 бүлэгт 1358 хүүхэд байгаагаас 155 малчдын хүүхэд хамрагдан хүмүүжиж байна. Цэцэрлэгийн бүлгийг тоогоор нь авч үзвэл яслийн бүлэг 3, бага бүлэг 10, дунд бүлэг 7, ахлах бүлэг 6, бэлтгэл бүлэг 7, холимог бүлэг 3, ээлжийн бүлэг 3, нүүдлийн бүлэг 4 байна.

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад 151 ажиллагсад байгаагаас 134 нь буюу 88.7 хувь нь эмэгтэй ажиллагсад байна.

Албан тушаалаар нь авч үзвэл:

- Эрхлэгч 9
- Арга зүйч 1
- Үндсэн багш 36
- Туслах багш 38
- Нягтлан бодогч 9
- Нярав 8
- Эмч 2
- Тогооч 16
- Үйлчлэгч 8
- Манаач, жижүүр 15,
- Бусад албан тушаалд 9 хүн тус тус ажиллаж байна.
-

8.3 2013-2014 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 5 сургуулийн 108 бүлэгт 2990 сурагч суралцаж байгаагаас I-V –р ангид 1454 сурагч, VI-IX-р ангид 930, X-XII-р ангид 606 сурагч суралцаж байна. ЕБС-д хөгжлийн бэрхшээлтэй 1, дотуур байранд 146 сурагч байна

2013-2014 оны хичээлийн жилд 325 хүүхэд 1-р ангид элсэн орсон байна. Насны ангиллаар нь авч үзвэл 5 ба доош настай 35, 6 настай 282, 7 настай 8 хүүхэд байлаа.

ЕБС-д 268 ажиллагсад үүнээс 221 нь буюу 82,5 хувь нь эмэгтэй байна.

Албан тушаалаар нь авч үзвэл:

- Захирал 4
- Сургалтын менежир 9

- Нийгмийн ажилтан 5
- Үндсэн багш 167
- Цагийн багш 5
- Байрны багш 3
- Нягтлан бодогч 5
- Нярав 5
- Үйлчлэгч 22
- Манаач, жижүүр 21
- Бусад албан тушаалд 22 хүн тус тус ажиллаж байна.

167 үндсэн багш ажиллаж байгаа ба нэг багшид ногдох суралцагчийн тоо 17,9 байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал: Сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан хүүхдийн тоо 10,9 хувиар, Ерөнхий боловсролын сургуульд суралцагчдын тоо 0,8 хувиар, нэг багшид ногдох суралцагч 5,3 хувиар тус тус нэмэгдсэн байна.

9. ЭРҮҮЛ МЭНД ,ЭМ ТАРИА

9.1 Аймгийн хэмжээний эрүүл мэндийн үзүүлэлтийг жилийн эцсийн байдлаар Эрүүл мэндийн газрын мэдээгээр авч үзвэл:

- Халдварт бус өвчлөл 4923
- Хорт хавдарын өвчлөл 14
- Осол гэмтлийн өмчлөл 680
- Халдварт өвчин 195 бүртгэгдсэн байна.

Халдварт өвчний өвчлөлийг төрлөөр нь танилцуулбал :

дд	Үзүүлэлт	2013 он	
		Өвчлөл	Нас баралт
1	Цусан суулга	10	-
2	Сальмонеллез	-	-
3	Вируст гепатит	11	-
4	Сүрьеэ	20	1
5	Менингококт халдвар	-	-
6	Гахайн хавдар	31	-
7	Салхин цэцэг	24	-
8	Сүрьеэ	-	-
9	Гар хөл амны өвчин	3	-
10	Мөөгөнцөр	-	-
11	Заг хүйтэн	22	-
12	Тэмбүү	63	-
13	Трихоманиаз	11	-
14	Улаанбурхан	-	-
15	Ёлом	-	-
Нийт		195	1

Халдварт өвчин жилийн эцсийн байдлаар 195 байна. Үүний 32,3 хувь нь тэмбүү, 15,9 хувь нь гахайн хавдар, 12,3 хувь нь салхин цэцэг өвчин байлаа. Нийт халдварт өвчний 96 буюу 49,2 хувийг БЗХӨ эзэлж байна.

Өмнөх оны мөн үетэй харьцуулбал:

Халдварт бус өвчлөл 38,3 хувиар

Халдварт өвчний өвчлөл 1,5 хувиар тус тус буурч

Осол гэмтлийн өвчлөл 8,9 хувиар өссөн байна.

2013 оны байдлаар осол гэмтлээр 14 хүн, хорт хавдраар 10 хүн нас барсан байна.

Нийт үзлэгийн тоог хүснэгтээр танилцуулбал:

дд	Үзүүлэлт	Үзлэгийн тоо	Эзлэх хувь
1	Нийт үзлэг	108804	100,0
2	Үүнээс: Урьдчилан сэргийлэх үзлэг	34643	31,8
3	Амбулаторын үзлэг	53168	48,9
4	Идэвхтэй хяналтын үзлэг	13059	12,0
5	Гэрийн үзлэг	7407	6,8
6	Гэрийн дуудлага	527	0,5

Түргэн тусламжийн дуудлага 6322 гарсны 466 нь буюу 7,4 хувь нь алсын дуудлага байлаа.

9.2 Аймгийн хэмжээнд 5 эмийн сан ажиллаж байгаа бөгөөд тайлант онд 504,5 сая төгрөгийн эм тариа татан авч 496,3 сая төгрөгийн эм тариа борлуулсан байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад эм тариа татан авалт 18,2 хувиар өссөн , эм тарианы борлуулалт 19,5 хувиар өссөн байна.

Үүнээс: Аймгийн төв эмийн сан 167,1 сая төгрөгийн эм тариа татан авалт хийсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 14,9 хувиар өссөн байна., 158,7 сая төгрөгийн эм тариаг борлуулсан нь өмнөх оноос 3,2 хувиар өссөн байна. Оны эцсийн эм тариа бусад зүйлийн нөөц 45,9 сая төгрөг байгаа нь өмнөх оноос 13,9 хувиар өссөн байна.

10. ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭ, ҮНЭ

10.1 2013 оны байдлаар Экспортын бараа бүтээгдэхүүний биет хэмжээ 171,3 мян.тн, нийт үнийн дүн нь 33,9 сая.доллар болоод байна. Энэ нь өмнөх сартай харьцуулахад биет хэмжээ 14,7 хувиар , үнийн дүн нь 11,8 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Импортын бараа бүтээгдэхүүний биет хэмжээ 85,2 мян.тн , үнийн дүн нь 96,7 сая.долларт хүрсэн байна. Энэ нь өмнөх сартай харьцуулахад биет хэмжээ 8,9 хувиар, үнийн дүн нь 8,2 хувиар буюу 1,1 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

10.2 Бизнес ригестрийн сангийн бүртгэлээр худалдааны салбарт 47 аж ахуй нэгж бүртгэгдсэнээс ҮСХ- ны батлагдсан хүрээгээр худалдаа үйлчилгээний 13 аж ахуй нэгж байгууллага 2013 оны мэдээ тайланд хамрагдсан байна.

2013 оны мэдээллээр худалдааны салбарын орлого 74,1 тэрбум төгрөг , Тайлант хугацаанд борлуулсан бараа бүтээгдэхүүний өртөг 65,5 тэрбум төгрөгт хүрснийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт орлого 50,3 тэрбум буюу 32,1 хувиар , борлуулсан бараа бүтээгдэхүүний өртөг 41,8 тэрбум төгрөг буюу 36,2 хувиар тус тус өссөн байна.

Тайлант онд хүрээнд хамрагдсан 13 нэгжид 218 хүн ажилласан байна.

10.3 Манай аймагт албан бус сектор 172 бүртгэгдсэн бөгөөд 5421,3 сая төгрөгний орлоготой ажиллаж, 4441,5 сая төгрөгний зардал гаргаж, 979,7 мянган төгрөгний ашигтай ажилласан байна. Үүнээс худалдаа 103 нэгж, гуанз цайны газар 6 нэгж, тээвэр 36 нэгж, боловсруулах үйлдвэр 10 нэгж, үйлчилгээний салбар 13 нэгж, тоглоомын газарт 4 нэгж хамрагдсан байна.

10.4 Өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ өмнөх онтой харьцуулахад үнийн өсөлт өндөр байна. Оны эхнээс оны эцэс хүртэл гурил 110 төгрөг буюу 14,7 хувиар, Цагаан будаа 30,4 хувиар , элсэн чихэр 23,8 хувиар , шингэн сүү 16,7 хувиар өссөн бол махны үнийн хэлбэлзэл 200-1000 төгрөгийн хооронд буюу ойролцоогоор 21,5 хувийн үнийн хэлбэлзэлтэй байлаа.

Ноолуурын үнэ жилийн 3-7 сарын үед өндөр буюу 50000 - 70000 байсан бол бусад саруудад тогтмол буюу 40000-50000 төгрөгийн хооронд байна.

Шатахуун, түлшний үнэ оны эхний хагасд сүүлийн хагас жилээс дунджаар 50 төг буюу 3,4 хувиар өссөн үзүүлэлттэй байна

№	Барааны нэр	2013 он			
		1-р сар	6-р сар	12-р сар	Жилийн дундаж өсөлт
1	Гурил 1-р зэрэг	640	650	750	14,7
2	Хонины мах /кг/	5000	6500	5500	21,5
3	Үхрийн мах /кг/	6800	8000	7000	
4	Ямааны мах /кг/	4500	6000	4400	
5	Элсэн чихэр /кг/	1600	1600	1700	23,8
6	Цагаан будаа /кг/	1600	1600	2300	30,4
7	Шингэн сүү /л /	1000	1000	1200	16,7
8	Ноолуур /кг/	40000	70000	55000	24,2
9	Ноолуур /хуучин/	30000	50000	50000	
10	А-80	1400	1450	1450	3,4
11	АИ-92	1670	1710	1710	
12	ДТ	1800	1800	1800	

11. ГЭМТ ХЭРЭГ

Аймгийн хэмжээнд 179 гэмт хэрэг бүртгэгдсэн ба тус гэмт хэргийн 98 нь буюу 54,7 хувь нь хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг байлаа. Гарсан гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс 11,9 хувиар өссөн байна. Гэмт хэрэгт холбогдогсод 184, үүний 72 нь буюу 39,1 хувь нь 18-30 насны иргэд байгаа ба 86 нь буюу 46.7 хувь нь ажилгүй иргэд байна. Гэмт хэрэгт холбогдогсдыг өмнөх оны мөн үетэй харьцуулбал 13,6 хувиар өссөн байна.

Давхардсан тоогоор 1541 хүн эрүүлжүүлэгдэж , 211 хүн баривчлагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад эрүүлжүүлэгдсэн хүний тоо 56,4 хувиар , баривчлагдсан хүний тоо 73,0 хувиар өссөн үзүүлэлт гарлаа.

Гэмт хэрэг зөрчлийг төрлөөр нь танилцуулбал:

дд	Гэмт хэргийн төрөл	Хэргийн тоо		Өсөлт бууралт	
		2012 он	2013 он	тоо	хувь
1	Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг	78	98	20	25,6
2	Хүүхэд гэр бүлийн нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг	3	1	-2	-33,3
3	Иргэдийн улс төрийн болон эрх чөлөө	1	1	0	0
4	Өмчлөх эрхийн эсрэг	40	40	0	0
5	Аж ахуйн гэмт хэрэг	2	0	-2	-100
6	Нийгмийн аюулгүй байдлын эсрэг	11	8	-3	-27,3
7	Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	0	3	3	3 дахин
8	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	15	22	7	46,7
9	Захиргааны журмын эсрэг гэмт хэрэг	7	3	-4	-57,1
10	Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг	3	2	-1	-33,3
11	Албан тушаалын гэмт хэрэг	0	1	1	1 дахин
	Бүгд	160	179	19	11,9

Гэмт хэрэг илрүүлэлт жилийн эцсийн байдлаар 46,7 хувьтай байна. Энэ онд онц хүнд гэмт хэрэг 3, хүнд гэмт хэрэг 9, хүндэвтэр гэмт хэрэг 52, хөнгөн гэмт хэрэг 115 бүртгэгдсэн байна.

Гэмт хэргээс учирсан хохирол 224.5 сая төгрөг, нөхөн төлүүлсэн нь 148.3 сая төгрөгт хүрсэн байна.

12. ЦАГ УУР

2013 онд агаарын температур өвлийн сард шөнөдөө 20...25 градус хүйтэн, өдөртөө 10...15 градус хүйтэн байсан. Хаврын сарын эхээр шөнөдөө 5...10 градус хүйтэн, өдөртөө 3-8 градус дулаан, хаврын сарын сүүлээр шөнөдөө 6 градус дулаан, өдөртөө 22 градус дулаан байсан. Зуны сард шөнөдөө 11...14 градус дулаан, өдөртөө 23...26 градус дулаан байсан. Намрын сарын эхэнд шөнөдөө 4 градус дулаан, өдөртөө 20 градус дулаан, намрын сарын сүүлээр 5...10 градус хүйтэн, өдөртөө 3...8 градус дулаан байсан.

Энэ жилийг 2012 онтой харьцуулбал өвөлдөө 3 градусаар, хавартаа 1...2 градусаар дулаан, зундаа бага зэрэг сэрүүхэн, намрын сүүл сард 4 градусаар дулаан байсан байна.

Хөрсний температур өвлийн сард шөнөдөө 23...28 градус хүйтэн, өдөртөө 5...10 градус хүйтэн байсан. Хаврын сарын эхээр шөнөдөө 8...13 градус хүйтэн, өдөртөө 18...23 градус дулаан, хаврын сарын сүүлээр шөнөдөө 3 градус дулаан, өдөртөө 46 градус дулаан байсан. Зуны сард шөнөдөө 9...14 градус дулаан, өдөртөө 46...48 градус дулаан байсан. Намрын сарын эхэнд шөнөдөө 2 градус дулаан, өдөртөө 36 градус дулаан, намрын сарын сүүлээр 7...12 градус хүйтэн, өдөртөө 10...15 градус дулаан байсан.

2013 оныг өмнөх жилтэй харьцуулбал өвөл, хавар, намартаа арай дулаан, зундаа өмнөх жилтэй ойролцоо байсан байна.

Салхи өвлийн сард дундажаар 2-3 м/сек, хамгийн их нь 2 дугаар сард 14 м/сек хүрсэн байна. Хаврын сард дундажаар 3-4 м/сек, хамгийн их нь 4 дугаар сард 20 м/сек хүрсэн байна. Зуны сард дундажаар 1-3 м/сек, хамгийн их нь 6 дугаар сард 12 м/сек хүрсэн байна. Намрын сард дундажаар 2-4 м/сек, хамгийн их нь 10 дугаар сард 14 м/сек хүрсэн байна.

Өмнөх жилийг бодвол хаврын сард салхи ихтэй байсан.

2013 онд нийт 125.7 мм хур тунадас унасан ба хүйтний улиралд 15.4 мм, дулааны улиралд 110.3 мм бороо орсон байна. 2012 оныг бодвол өвөл, хавар болон зуны эхэн сард хур тунадас ихтэй, зуны сүүл болон намрын сард өмнөх жилийнхээс бага хур тунадас орсон байна.

13. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА

Говьсүмбэр аймаг 2013 онд Улсын төсвийн болон аймаг, сумдын Орон нутгийн хөгжил сангийн хөрөнгө оруулалтаар нийт 109 төсөл, арга хэмжээг 8249,2 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Үүнд: Нээлттэй тендер шалгаруулалтын журмаар 28, Харьцуулалтын журмаар 49, Шууд худалдан авах журмаар 29, Олон нийтийн оролцоотой 3 төсөл, арга хэмжээ хамрагдаж байна.

Д д	Хөрөнгө оруулалт	Сонгон шалгаруулалт				Төлөвлөгдсөн бараа үйлчилгээ	Зарлагдсан тендер	Төлөвлөсөн төсөв / сая төг /	Гэрээлэгдсэн төсөв / ая төг/
		Нээлттэй тендер	Харьцуулалты н журмаар	Шууд худалдан авалт	Олон нийтийн оролцоотой				
1	Улсын төсвийн	6	2			8	7	1155,0	1625,8
2	Аймгийн орон нутгийн хөгжил сан	7	13	7		27	24	2773,0	3337,5
3	Сүмбэр сумын ЗДТГ-н захиалгаар	8				8	6	1470,0	573,6
4	Сүмбэр сумын орон нутаг сан		13	13	1	27	24	540,8	452,2
5	Баянтал сумын орон нутаг сан	5	13	8		26	19	1192,2	1007,3
6	Шивээговь сумын орон нутаг сан	2	8	1	2	13	9	1118,2	944,1
7	Нийт	28	49	29	3	109	89	8249,2	7940,5